




ЗӨВШӨӨРӨВ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРАЛ
М.ОДГЭРЭЛ

БАТЛАВ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД, УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АНАГААХ УХААН
СУДЛАЛЫН МЭРТӨЖЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ЕРӨНХИЙ МЭРГЭЖИЛТЭН
Л.УНДРАМ



ӨРХ, СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Сургалтын хугацаа: 3 сар

Улаанбаатар хот

2025 он

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:

Д.Даваалхам, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн захирал, Анагаах ухааны доктор, профессор

М.Ундрэм, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн Сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний газрын дарга, Анагаах ухааны доктор

С.Эвлэгсүрэн, Азийн хөгжлийн банкны “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг боловсронгуй болгох нь” техник тусалцааны төслийн дотоодын зөвлөх

Ц.Энх-Оюун, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Эпидемиологи, биостатистикийн тэнхим, Анагаах ухааны доктор, дэд профессор

А.Энхжаргал, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Орчны эрүүл мэндийн албаны эрдэм шинжилгээний ажилтан, Анагаах ухааны доктор

Д.Оюунгэрэл, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Тандалтын албаны томуугийн нэгжийн дарга, Нийгмийн эрүүл мэндийн магистр

С.Амарзаяа, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Тандалтын албаны халдварын хяналтын тасгийн дарга

Н.Алтанзул, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн сургалт, эрдэм шинжилгээний албаны дарга, Анагаах ухааны доктор

Э.Пүрэвсүрэн, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хоол судлал, хүнсний аюулгүй байдлын албаны дарга, Нийгмийн эрүүл мэндийн магистр

Б.Баярмаа, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга, Нийгмийн эрүүл мэндийн ахлах зэрэг

М.Хишгээ, “Эрүүл мэндийн форум” төрийн бус байгууллагын захирал, Нийгмийн эрүүл мэндийн магистр

ХАМТРАН АЖИЛЛАСАН:

Б.Ганбат, ЭМЯ, Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн Өрийг эрүүл мэндэд хөрвүүлэх хөтөлбөрийн мэргэжилтэн, Анагаах ухааны доктор

Ш.Солонго, ЭМХТ-ийн гадаад харилцаа, төсөл хөтөлбөрийн мэргэжилтэн, Нийгмийн эрүүл мэндийн магистр

ХЯНАСАН:

Д.Дондогмаа, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга

Ц.Даваахүү, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны мэргэжилтэн

ӨРХ, СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ДАВТАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Нийгмийн эрүүл мэндийн гол зорилго нь өвчин, гэмтэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэнд ба сайн сайхан байдлыг дэмжих, өвчнөөс ангид орчин бүрдүүлэхэд оршдог. Үүний тулд өвчин, эмгэгийн суурь шалтгаануудыг илрүүлэн шийдвэрлэх, эрүүл мэндэд нөлөөлдөг өргөн хүрээний нийгмийн, эдийн засгийн, байгаль орчны хүчин зүйлсийг тогтоож, хүн амын түвшний системтэй бодлогын шийдлүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Монгол улсын эрүүл мэндийн тогтолцоонд анхан шатны тусламж, үйлчилгээний чанар болон хүртээмж нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн мэргэжлийн чадавхаас шууд хамаардаг. Эдгээр төвүүдэд ажиллаж буй нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн мэргэжилтнүүд эрүүл мэндийн нийгмийн ажилтан, нийгмийн эрүүл мэнд судлалч, эрүүл ахуйч, тархвар судлалч нь хүн амын эрүүл мэндийн хэрэгцээг илрүүлэх, эрсдэлийн хүчин зүйлсийг үнэлэх, өвчлөлийн мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах, зан үйлийн өөрчлөлтийн дэмжлэг үзүүлэх, орон нутгийн олон талт оролцогчдыг уялдуулах зэрэг нийгмийн эрүүл мэндийн үндсэн үүргийг гүйцэтгэдэг гол хүний нөөц юм. Гэвч практик орчны онцлог, ажлын ачаалал, сургалтын ялгаатай түвшин зэрэг хүчин зүйлээс шалтгаалан тэдгээрийн ур чадвар нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/-аас тодорхойлсон нийгмийн эрүүл мэндийн 12 чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд ижил бөгөөд хангалттай түвшинд байдаггүй нь олон үнэлгээ, хөтөлбөрийн хэрэгжилтийн дүнгээс харагдаж байна. Тухайлбал, тандалтын мэдээллийн чанар, эрсдэлийн үнэлгээ, олон нийтийн оролцоотой зан үйлийн өөрчлөлтийн стратеги төлөвлөлт, хөтөлбөрийн төлөвлөлт-хяналт-үнэлгээ, салбар хоорондын уялдаа, эрсдэлийн харилцаа зэрэг чиглэлд чадамжийн цоорхой давтагдсан хэвээр байна. Иймээс олон улсын жишигт нийцсэн, EPHF-ийн (Essential Public Health Functions) чадамж, практик үйл ажиллагааны багцыг суурь болгон боловсруулсан, анхан шатны түвшний нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэнд зориулсан системтэй, тасралтгүй мэргэжил дээшлүүлэх сургалт шаардлагатай байна. Энэхүү хөтөлбөр нь дээрх хэрэгцээг нөхөх, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн чадавхыг нэмэгдүүлэх, хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтийг сайжруулахад чиглэсэн.

ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО

Анхан шатны түвшинд ажиллаж буй нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн ДЭМБ-ын тодорхойлсон Нийгмийн эрүүл мэндийн 12 чиг үүргийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, чадамж эзэмшиж, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг нотолгоонд суурилан төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх чадавх эзэмших.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Анхан шатны түвшний нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн бүр НЭМ-ийн үндсэн чиг үүргийг бүрэн, чанартай, тасралтгүй хэрэгжүүлж чаддаг; орон нутгийн хүн амын хэрэгцээнд тулгуурласан бодит шийдвэр гаргадаг; олон талт хамтын ажиллагааг удирдан зохион байгуулдаг; нотолгоонд суурилсан хөтөлбөр төлөвлөлт, хяналт-үнэлгээний чадавхтай эрүүл мэндийн тогтолцооны тогтвортой тулгуур хүч болон төлөвшинө.

ДӨРӨВ. СУРГАЛТААР ЭЗЭМШИХ ЧАДАМЖ

Сургалтын төгсгөлд Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн эрүүл мэндийн анхан шатны тусламжийн түвшинд нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 7 бүлэг чадамжийг эзэмшсэн байна.

Сургалт дүүргэсэн эрүүл мэндийн ажилтан дараах суурь чадамжийг эзэмшинэ.

1. Тандалт, мэдээллийн менежмент (EPHF 1, 2, 3)
2. Эрсдэлийн илрүүлэлт, анхан шатны үнэлгээ (EPHF 4)
3. Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, зан үйлийн үнэлгээ (EPHF 1, 7, 8)
4. Хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийн мониторинг (EPHF 5, 6, 7)
5. Эрсдэлийн харилцаа, олон нийтийн оролцоо (EPHF 9, 10)
6. Салбар хоорондын хамтын ажиллагаа, багийн ажиллагаа (EPHF 11, 12)
7. Байгууллагын түвшний үр дүнд чиглэсэн практик чадамж (EPHF бүх чиглэлтэй уялдсан)

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

1. Тандалт, мэдээллийн менежмент (EPHF 1, 2, 3)

- Өрх, сумын түвшний тандалтын үйл ажиллагааг стандарт дагуу зохион байгуулах.

- Өдөр, долоо хоног, сарын тандалтын мэдээг алдаагүй, бүрэн бөглөх, мэдээллийн чанарын алдаа илрүүлж засах.
- Шинэ тохиолдол, тархалт, зонхилон тохиолдох өвчлөл, нас баралтын хувьд суурь үзүүлэлтийг тооцох, зөв тайлбарлах, өрх, сумын түвшний нөхцөл байдалд үнэлгээ өгөх.
- Энгийн өгөгдлийг цэвэрлэх, нэгтгэх, дүрслэх, шийдвэр гаргалтад ашиглах үндсэн график, хүснэгт гаргах.
- Эрүүл мэндийн төвийн тандалтын багаас ирсэн мэдээллийг багийн уулзалтаар танилцуулж, хариу арга хэмжээний санал гаргах.

2. Эрсдэлийн илрүүлэлт, анхан шатны үнэлгээ (EPHF 4)

- Халдварт өвчний тохиолдол нэмэгдэх, голомт үүсэх сэжигтэй нөхцөлд Сэрэмжлүүлэх дохио- босго утга- анхааруулах дохио (trigger–threshold–alert) үзүүлэлт ашиглан эрт илрүүлэлт хийх.
- Анхан шатны эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ (Rapid Risk Assessment-RRA)-г орон нутгийн нөхцөлд тохируулан 5–7 алхмаар гүйцэтгэх.
- Илэрсэн эрсдэлийн талаар баг, удирдлага болон орон нутгийн бусад байгууллагад ойлгомжтой хэлээр тайлан мэдээлэх.
- Эрсдэлийн бууруулах богино хугацааны арга хэмжээний санал боловсруулах.

3. Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, зан үйлийн үнэлгээ (EPHF 1, 7, 8)

- Өрх, сум, тосгоны хүн амын эрүүл мэндийн хэрэгцээний үндсэн мэдээллийг тогтмол цуглуулах, бүлэглэлээр шинжлэх.
- Нийгмийн эрүүл мэндийн асуудлын “шалтгаан–үр дагаврын зураглал” (problem tree) гаргах чадамжтай болох.
- Зан үйлийн эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлох, энгийн зан үйлийн үнэлгээ хийх.
- Хүн амын бүлэгт тохирсон зан үйлийн өөрчлөлтийн хөтөлбөрийн богино төлөвлөгөө боловсруулах.

4. Хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийн мониторинг (EPHF 5, 6, 7)

- Орон нутгийн нийгмийн эрүүл мэндийн асуудлыг тодорхойлж, түүнд нийцсэн зорилго, зорилт, санал болгож болох арга хэмжээг тодорхойлох.
- Логик хүрээ, SMART үзүүлэлт бүхий богино хөтөлбөрийн төлөвлөгөө гаргах.

- Хэрэгжилтийн мониторинг хийхэд шаардагдах хяналт, үнэлгээний энгийн матриц, үзүүлэлтийн тайлбар хуудас (indicator reference sheet) боловсруулах.
- Үр дүнг тайлагнах энгийн, товч тайлан бэлтгэж сурах.

5. Эрсдэлийн харилцаа, олон нийтийн оролцоо (EPHF 9, 10)

- Хэвийн болон онцгой нөхцөлд олон нийттэй харилцах суурь зарчим (RCCE)-ийг үйл ажиллагаандаа ашиглах.
- Орон нутгийн хүн амын ойлголт, хандлагад суурилан богино, тодорхой мессеж боловсруулах.
- Ташаа мэдээллийн эрсдэлийг таних, энгийн түвшинд үнэлэх, мэдээллийн шуурхай хариу өгөх.
- Олон нийттэй харилцах арга зүйг ашиглан эрүүл мэндийн төв, орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх.

6. Салбар хоорондын хамтын ажиллагаа, багийн ажиллагаа (EPHF 11, 12)

- НЭМ-ийн асуудлаар холбогдох талуудын зураглал (stakeholder mapping) гаргах.
- Багийн уулзалтыг богино хөтөлбөрөөр удирдах, шийдвэрийн санал дэвшүүлэх.
- Салбар хоорондын хамтын ажиллагааны уулзалт, зөвлөлдөх хэлэлцүүлгийг зохион байгуулахад идэвхтэй оролцох.
- Нийгмийн эрүүл мэндийн ёс зүй, хүн төвтэй хандлагыг өдөр тутмын ажилдаа хэрэгжүүлэх.

7. Байгууллагын түвшний үр дүнд чиглэсэн практик чадамж (EPHF бүх чиглэлтэй уялдсан)

- ЭМТ-ийн тандалтын мэдээллийн чанарыг долоо хоног бүр үнэлж сайжруулах.
- Эрсдэл илэрсэн үед анхан шатны хариу арга хэмжээний санал боловсруулах.
- Орон нутгийн НЭМ-ийн асуудлаар 1–2 сарын богино төлөвлөгөө гаргах.
- Багийн болон салбар хоорондын уулзалтад асуудлаа нотолгоонд тулгуурлан танилцуулж, шийдлийн хувилбар санал болгох.

ЗУРГАА. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

Сургалтын чиглэл, сургалт явагдах газар:

Сургалт эрхлэх байгууллагад тавигдах шаардлага хангаж, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс эрүүл мэндийн ажилтанд зориулсан “Нийгмийн эрүүл мэнд судлал” сургалт эрхлэх зөвшөөрөл авсан байгууллага энэхүү сургалтыг явуулна.

Зорилтот бүлэг

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд ажиллаж буй нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, эрүүл мэндийн нийгмийн ажилтан, нийгмийн эрүүл мэнд судлалч, эрүүл ахуйч, тархвар судлалч нарыг хамруулах бөгөөд ДЭМБ-аас тодорхойлсон Нийгмийн эрүүл мэндийн 12 үндсэн чиг үүргийг (EPHF) Монгол Улсын хууль, эрх зүй, үндэсний хөтөлбөрүүд болон орон нутгийн бодит хэрэгцээтэй уялдуулан эзэмшүүлэхэд чиглэнэ. Хөтөлбөр нь нийгмийн эрүүл мэндийн тандалт, эрсдэлийн илрүүлэлт ба анхан шатны үнэлгээ, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа, зан үйлийн зөвлөгөө, олон нийтийн оролцоо ба эрсдэлийн харилцаа, эрүүл мэндийн мэдээллийн системийн ашиглалт, орчны болон хөдөлмөрийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, эм, вакцины зохистой хэрэглээ зэрэг өргөн хүрээний чадамжийг хамарна.

Сургалтын нийт хугацаа Сургалт нь нийт 3 сар 12 долоо хоногийн хугацаанд танхимын сургалт, онлайн хэлбэр, ажлын байран дахь дадлагыг хослуулсан бүтэцтэйгээр зохион байгуулагдана.

Танхимын сургалт сургалт эрхлэх байгууллага дээр /сургалтын сүлжээ эмнэлэг, аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв болон батлагдсан сургалтын бааз/ явагдах ба ажлын байрны дадлага нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бодит үйл ажиллагаанд оролцох байдлаар хэрэгжинэ. Онлайн сургалт нь оролцогчдын цагийн боломжид нийцсэн уян хатан хэлбэрээр видео хичээл, сорил, форум хэлэлцүүлэг болон портфолио үнэлгээний цахим орчныг ашиглан явагдана.

Сургалтын төлөвлөгөө, агуулга

Энэхүү сургалтын агуулга нь ДЭМБ-ын тодорхойлсон нийгмийн эрүүл мэндийн 12 үндсэн чиг үүрэг, Монгол улсын нийгмийн эрүүл мэндийн хууль эрх зүйн зохицуулалт, анхан шатны тусламж үйлчилгээний байгууллагын бодит хэрэгцээ, цөм хөтөлбөрийн 12 цөм агуулгад тулгуурлан боловсруулагдсан. Агуулга нь эрүүл мэндийн ажилтны өдөр тутмын үйл ажиллагаа, хүн амын эрүүл мэндийн эрсдэлийг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, орон нутгийн түвшний эрүүл мэндийг дэмжих, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжихэд чиглэнэ.

Сургалтын төлөвлөгөө нь 12 долоо хоногийн модульт бүтэцтэй бөгөөд модуль бүр нь тодорхой чадамжийг эзэмшүүлэх зорилготой логик дараалал, онол–практикийн хосолсон аргачлалтай. Сургалтын үйл явц нь лекц, семинар, кейс судалгаа, орчны ба байгууллагын түвшний дадлага, вебинар, багийн ажил, бие даалтын бодит даалгавар зэргийг хослуулсан хосолмол сургалтын загвараар зохион байгуулагдана.

Модуль бүрийн төгсгөлд богино хэлбэрийн явцын үнэлгээ, сургалтын төгсгөлд мэдлэг–чадварын нэгдсэн шалгалт болон портфолио хамгаалалт хийгдэнэ. Ингэснээр суралцагч нь эзэмшсэн мэдлэг, ур чадвараа ажлын байран дээр бодитоор хэрэгжүүлж чаддаг эсэхийг баталгаажуулна.

Сургалтын төлөвлөгөө

Долоо хоног	Хамрагдах модуль	Товч агуулга / Онцлог	Хамрагдах үнэлгээ
1-р долоо хоног	Модуль 1: Нийгмийн эрүүл мэндийн үндэс ба ЕРНФ	Нийгмийн эрүүл мэндийн 12 чиг үүрэг, хууль эрх зүй, анхан шатны байгууллагын үүрэг, мэргэжилтний чадамж	Танхимын оролцооны үнэлгээ, богино сорил
2-р долоо хоног	Модуль 2: Тандалтын үйл ажиллагаа	Өдөр/долоо хоног/сарын тандалтын бүртгэл, мэдээллийн чанар шалгах, алдааг засах	Дадлагын ажлын үнэлгээ
3-р долоо хоног	Модуль 2 үргэлжлэл	Суурь эпидемиологийн үзүүлэлтүүдийг (шинэ тохиолдол, тархалт, хуримтлагдсан өвчлөл, нас баралтын хувь) тооцох; өгөгдөл цэвэрлэх, нэгтгэх, дүрслэх	Өгөгдөл боловсруулах дасгал (хэсэгчилсэн үнэлгээ)
4-р долоо хоног	Модуль 3: Эрсдэлийн илрүүлэлт ба түргэвчилсэн үнэлгээ	Сэрэмжлүүлэх дохио–босго утга–анхааруулах дохио ашиглан эрт илрүүлэлт хийх; Түргэвчилсэн эрсдэлийн үнэлгээ (5–7 алхам)	Симуляц/дасгал

Долоо хоног	Хамрагдах модуль	Товч агуулга / Онцлог	Хамрагдах үнэлгээ
5-р долоо хоног	Модуль 4: Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээний үнэлгээ	Суурь мэдээлэл цуглуулах, бүлгээр шинжлэх; НЭМ-ийн асуудлын “шалтгаан–үр дагаврын мод” боловсруулах	Бие даалтын ажлын үнэлгээ
6-р долоо хоног	Модуль 4 үргэлжлэл	Эрсдэлт зан үйл тодорхойлох, зан үйлийн энгийн үнэлгээ хийх; Зорилтот бүлэгт чиглэсэн зан үйлийн төлөвлөгөө гаргах	Зан үйлийн төлөвлөгөөний үнэлгээ
7-р долоо хоног	Модуль 5: Эрүүл мэндийг дэмжих ба эрсдэлийн харилцаа (RCCE)	Эрсдэлийн харилцааны зарчим; Ташаа мэдээллийг таних, хариу арга хэмжээ боловсруулах; Мессеж боловсруулах	эрсдэлийн харилцааны мессеж боловсруулах дасгал
8-р долоо хоног	Модуль 5 үргэлжлэл	Олон нийтийн оролцооны арга зүй (community mapping, stakeholder engagement); Сайн дурын оролцоо дэмжих	Бүлгийн ажлын үнэлгээ
9-р долоо хоног	Модуль 6: Хөтөлбөрийн төлөвлөлт	Асуудлын тодорхойлолт; Логик хүрээ боловсруулах; SMART үзүүлэлт тодорхойлох	Логик хүрээний үнэлгээ (хэсэгчилсэн)
10-р долоо хоног	Модуль 6 үргэлжлэл	Хяналт–үнэлгээний матриц (M&E); Үзүүлэлтийн тайлбар хуудас; Тайлан бичих арга зүй	Тайлан бичих богино сорил + хяналт, үнэлгээний төлөвлөгөө боловсруулах
11-р долоо хоног	Модуль 7: Ажлын байрны дадлага	Тандалтын чанарын үнэлгээ хийх; Эрсдэлийн хариу арга хэмжээ боловсруулах; Олон	Дадлагын багшийн үнэлгээ

Долоо хоног	Хамрагдах модуль	Товч агуулга / Онцлог	Хамрагдах үнэлгээ
		нийтийн оролцооны жижиг төсөл	
12-р долоо хоног	Модуль 7 үргэлжлэл, нэгтгэл	Байгууллагын гүйцэтгэлийг сайжруулах богино хугацааны төлөвлөгөө боловсруулах; Багийн танилцуулга; Portfolio хамгаалалт	Portfolio (эцсийн) + OSPE шалгалт

ДОЛОО. СУРГАЛТЫН АГУУЛГА

МОДУЛЬ 1. Нийгмийн эрүүл мэндийн үндэс ба EPHF

Зорилго

Нийгмийн эрүүл мэндийн үндсэн ойлголт, EPHF-ийн үүргүүд болон Монгол Улсын хууль, бодлогын хэрэгжилт, анхан шатны байгууллагын бүтэцтэй уялдуулан мэргэжлийн түвшинд системтэй судлах.

Үндсэн агуулга

- Нийгмийн эрүүл мэндийн философи ба суурь зарчим
 - Эрүүл мэндийн тэгш байдал, хүн төвтэй хандлага
 - Нийгмийн тодорхойлогчдын нөлөө
 - Эрүүл мэндийн бодлого–эрүүл мэндийн үр дүнгийн уялдаа (policy → systems → outcomes)
- EPHF-ийн 12 чиг үүрэг
 - Чиг үүрэг бүрийн зорилт, шаардлагатай чадамж
 - Анхан шатны түвшинд хэрэгждэг бодит үйл ажиллагааны жишээ
 - Монгол улсын хууль, стандарт, үндэсний хөтөлбөр бүртэй холбож тайлбарлах
- Анхан шатны тусламжийн байгууллагын бүтэц, мэргэжилтний роль
 - Өрх, сумын ЭМТ-ийн бүтэц, чиг үүрэг
 - НЭМ мэргэжилтний уялдаа (тандалт, орчны эрүүл мэнд, сэтгэл–нийгмийн дэмжлэг, хөтөлбөр хэрэгжилт)
 - “Тохирох түвшний хариуцлага” (task-shifting, task-sharing)

Суралцахуйн үр дүн

- ЕРНФ чиг үүргийг онол–практикийн түвшинд ялган тайлбарлана.
- Анхан шатны НЭМ мэргэжилтний ажилбаруудыг ЕРНФ-тэй уялдуулна.
- Байгууллагынхаа НЭМ-ийн гүйцэтгэх чиг үүргийг үнэлэх боломжтой болно.

Хичээлийн зохион байгуулалт

- Лекц (2 цаг): ЕРНФ дэлгэрэнгүй тайлбар, Монголын хууль эрх зүйн орчин
- Дадлага (1 цаг): Байгууллагын ЕРНФ профайл гаргах
- Бие даалт (1 цаг): Өөрийн байгууллагын ЕРНФ хэрэгжилтийн үнэлгээ (1 хуудас)

Үнэлгээний арга

- Богино сорил (онол)
- Дадлагын оролцоо

МОДУЛЬ 2. Тандалтын үйл ажиллагаа ба мэдээллийн менежмент

Зорилго

Тандалтын мэдээллийг мэргэжлийн түвшинд боловсруулах, шинжлэх, алдаа засварлах, шийдвэр гаргалтад ашиглах ур чадварыг бэхжүүлэх.

Үндсэн агуулга

1. Тандалтын тогтолцоо ба стандарт
 - Тандалтын түвшин (өрх–сум–аймаг–улс)
 - Мэдээллийн урсгал, хариуцлага
 - Мэдээллийн чанарын шалгуур үзүүлэлтүүд: бүрэн байдал, давхардал, логик зөрчил, шалгуур зөрөх
2. Эпидемиологийн суурь үзүүлэлтүүд
 - Шинэ тохиолдол, тархалт
 - Хуримтлагдсан өвчлөл, нас баралтын түвшин
 - Хүүхдийн өвчлөл–хүн амын бүтцэд тохируулах
 - Тренд шинжилгээний үндэс (simple trend)
3. Өгөгдлийн инженерчлэлийн суурь
 - Өгөгдлийн цэвэрлэгээ
 - Өгөгдлийг баталгаажуулах
 - Өгөгдлийн дүрслэл
4. Тандалтын мэдээлэл, шийдвэр гаргалт

- ЭМТ дээр гардаг голлох шийдвэрүүд
- Хариу арга хэмжээний санал боловсруулах

Суралцахуйн үр дүн

- Тандалтын мэдээллийг алдаагүй бөглөнө, чанарын үнэлгээ хийнэ.
- Эпидемиологийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэлт гаргана.
- Өгөгдлийг зохион байгуулалттай цэвэрлэж, нэгтгэн, дүрслэл хийнэ.
- Тандалтын мэдээлэлд тулгуурлан шийдвэрийн санал боловсруулах чадвар эзэмшинэ.

Хичээлийн зохион байгуулалт

- Лекц (3 цаг): Тандалтын онол, үзүүлэлтүүд
- Дадлага (4 цаг): Мэдээ бөглөх дасгал, өгөгдөл цэвэрлэх, үзүүлэлт тооцох, график гаргах, тайлбарлах
- Бие даалт (2 цаг): Нэг сарын тандалтын мэдээллээс үндсэн үзүүлэлтүүд тооцох

Үнэлгээний арга

- Өгөгдөл боловсруулах төгсгөл шалгалт
- Хэсэгчилсэн шалгалт (үзүүлэлт тооцох)

МОДУЛЬ 3. Эрсдэлийн илрүүлэлт ба түргэвчилсэн үнэлгээ

Зорилго

Эрт илрүүлэлтийн алгоритм ашиглан хэвийн бус нөхцөл илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, хариу арга хэмжээний бодит санал боловсруулах чадвар олгох.

Үндсэн агуулга

1. Эрт илрүүлэлтийн алгоритм
 - Сэрэмжлүүлэх дохио (trigger)
 - Босро утга (threshold)
 - Анхааруулах дохио (alert)
 - сум–өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд үүсдэг нийтлэг дохионы жишээ
2. Түргэвчилсэн эрсдэлийн үнэлгээ
 - Алхам бүрийн дэлгэрэнгүй
 - Эрсдэлийн матриц
 - Хариу арга хэмжээний түвшин
 - Аймаг–сумын түвшний бодит жишээнүүд
3. Тайлагнал ба шийдвэр гаргалт

- Түргэвчилсэн эрсдэлийн үнэлгээний тайлан бичих
- Танилцуулга хийх
- Хариу арга хэмжээний санал

Суралцахуйн үр дүн

- Эрсдэлийн дохиог илрүүлнэ.
- Түргэвчилсэн эрсдэлийн үнэлгээ гүйцэтгэнэ.
- Хариу арга хэмжээний санал боловсруулна.
- Тайлан, танилцуулга бие даан хийнэ.

Хичээлийн зохион байгуулалт

- Лекц (2 цаг): Түргэвчилсэн эрсдэлийн үнэлгээний онол, арга зүй
- Дадлага (3 цаг): Симуляци (голомтын нөхцөл)
- Бие даалт (1 цаг): Түргэвчилсэн эрсдэлийн үнэлгээний тайлан бэлтгэх

Үнэлгээний арга

- OSPE өртөө – Түргэвчилсэн эрсдэлийн үнэлгээ хийх
- Дадлагын ажлын үнэлгээ

МОДУЛЬ 4. Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, зан үйлийн үнэлгээ

Зорилго

Хүн амын эрүүл мэндийн асуудалд шинжилгээ хийх, зан үйлийн үнэлгээний арга зүйг практикт ашиглах, зан үйл өөрчлөх богино хөтөлбөр боловсруулах чадвар олгох.

Үндсэн агуулга

1. Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ
 - Хүн амын бүлэглэл
 - Үндсэн зүүлэлтүүд (нярайн, нялхасын, бага насны хүүхдийн эндэгдлийн түвшин, нийт эндэгдлийн түвшин, өвчлөлийн бүтэц)
 - Өрхийн эрүүл мэндийн мэдээлэл ашиглах
2. Асуудлын шалтгаан–үр дагаврын шинжилгээ
 - Асуудлын шалтгаан, үр дагаварын мод
 - Үндсэн шалтгааны шинжилгээ
 - Эмзэг бүлгийг тодорхойлох
3. Зан үйлийн үнэлгээ
 - Эрсдэлт зан үйлийн ангилал
 - COM-B загвар

- Зан үйлийн зураглал
- 4. Зан үйл өөрчлөх хөтөлбөр
 - Зорилтот бүлгийг тодорхойлох
 - Хөшүүрэг тодорхойлох
 - Богино хугацааны төлөвлөгөө

Суралцахуйн үр дүн

- Хүн амын хэрэгцээг шинжилнэ.
- Асуудлын мод гаргана.
- Зан үйлийн үнэлгээ хийж, зан үйл өөрчлөх төлөвлөгөө боловсруулна.

Хичээлийн зохион байгуулалт

- Лекц (2 цаг)
- Дадлага (3 цаг): Асуудлын шалтгаан, үр дагаварын мод- воркшоп
- Бие даалт (2 цаг): Зан үйл өөрчлөх төлөвлөгөө

Үнэлгээний арга

- Асуудлын модны үнэлгээ
- Бие даалтын үнэлгээ

МОДУЛЬ 5. Эрүүл мэндийг дэмжих, олон нийтийн оролцоо ба эрсдэлийн харилцаа

Зорилго

Эрүүл мэндийг дэмжих арга зүйг хэрэглэх, олон нийтийг оролцуулах, эрсдэлийн мэдээллийг зөв цэгцтэй түгээх чадвар хөгжүүлэх.

Үндсэн агуулга

1. Эрүүл мэндийг дэмжих
 - Эрүүл мэндийг дэмжих Оттавагийн тунхаглал
 - Бие даасан бүлгийн эрүүл мэндийн дэмжлэг
 - Нийгмийн орчны нөлөөлөл
2. Эрсдэлийн харилцаа (RCCE)
 - Олон нийттэй харилцах таван зарчим
 - Хүнд нөхцөлд мэдээлэл өгөх арга
 - Ташаа мэдээлэл, инфодемик
3. Олон нийтийн оролцоо
 - Олон нийтийн зураглал боловсруулах
 - Холбогдох талуудыг татан оролцуулах

- Сайн дурын оролцоог дэмжих

Суралцахуйн үр дүн

- Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа төлөвлөнө.
- Эрсдэлийн харилцааны мессеж боловсруулна.
- Олон нийтийн оролцоог идэвхжүүлэх арга хэрэгжүүлнэ.

Хичээлийн зохион байгуулалт

- Лекц (2 цаг)
- Дадлага (3 цаг): Эрсдэлийн харилцааны мессеж боловсруулах семинар
- Бие даалт (1 цаг): Олон нийтийн оролцоог идэвхжүүлэх богино төлөвлөгөө

Үнэлгээний арга

- OSPE өртөө – Эрсдэлийн харилцааны төлөвлөгөө боловсруулах
- Бүлгийн ажлын үнэлгээ

МОДУЛЬ 6. Хөтөлбөрийн төлөвлөлт ба хяналт–үнэлгээ

Зорилго

Хөтөлбөр боловсруулах, SMART үзүүлэлт тодорхойлох, хяналт–үнэлгээний төлөвлөгөө гаргах чадварыг хөгжүүлэх.

Үндсэн агуулга

1. Асуудлын тодорхойлолт
 - Нотолгоонд суурилсан асуудал тодорхойлох
 - Инфографик ашиглах
2. Хөтөлбөрийн төлөвлөлт
 - Логик хүрээ (input–process–output–outcome–impact)
 - Зорилт тодорхойлох
3. Хяналт–үнэлгээ (M&E)
 - SMART үзүүлэлт
 - Хяналт, үнэлгээний матриц
 - Үзүүлэлтийн тайлбар хуудас
 - Тайлангийн бүтэц

Суралцахуйн үр дүн

- Логик хүрээ боловсруулна.
- SMART үзүүлэлт тодорхойлно.
- Хяналт, үнэлгээний матриц гаргана.
- Тайлан бичих чадвартай болно.

Хичээлийн зохион байгуулалт

- Лекц (2 цаг)
- Дадлага (4 цаг): Логик хүрээ боловсруулах
- Бие даалт (2 цаг): Хяналт, үнэлгээний төлөвлөгөө

Үнэлгээний арга

- Хяналт, үнэлгээний төлөвлөгөө боловсруулах ажлын үнэлгээ

МОДУЛЬ 7. Байгууллагын гүйцэтгэл ба ажлын байрны дадлага

Зорилго

Тандалт, эрсдэлийн үнэлгээ, зан үйл, Эрсдэлийн харилцааны, хяналт, үнэлгээний талаарх мэдлэгийг байгууллагын бодит нөхцөлд ашиглан гүйцэтгэлийн сайжруулалтын ажил төлөвлөх, хэрэгжүүлэх чадвар олгох.

Үндсэн агуулга

- Байгууллагын тандалтын чанарын үнэлгээ
- Эрсдэлийн хариу арга хэмжээ боловсруулах
- Олон нийтийн оролцооны жижиг төсөл
- Байгууллагын гүйцэтгэл сайжруулах богино хугацааны төлөвлөгөө
- Портфолио бүрдүүлэлт

Суралцахуйн үр дүн

- Байгууллагын гүйцэтгэлд үнэлгээ хийнэ.
- Сайжруулалтын төлөвлөгөө боловсруулна.
- Portfolio хамгаална.

Хичээлийн зохион байгуулалт

- Лекц: 1 цаг
- Дадлага: 5 цаг (ажлын байрны дадлага)
- Бие даалт: 3 цаг (Портфолио)

Үнэлгээний арга

- Портфолио эцсийн үнэлгээ
- OSPE өртөөчилсөн шалгалт
- Дадлагын үнэлгээ

НАЙМ. ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ

Энэхүү 3 сарын мэргэжил дээшлүүлэх сургалтын үнэлгээ нь чадамжид суурилсан үнэлгээний зарчмыг баримталж, суралцагчдын мэдлэг, ур чадвар, хандлагын ахиц дэвшлийг тасралтгүй хянах болон сургалтын төгсгөлд эзэмшсэн чадамжийг баталгаажуулах хоёр хэсгээс бүрдэнэ. Үнэлгээний зорилго нь суралцагчийн бодит ажлын байран дахь гүйцэтгэл болон EPHF-ийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай цогц чадамжийг хангалттай түвшинд эзэмшсэн эсэхийг тодорхойлох юм.

1. Явцын үнэлгээ (Formative assessment)

Сургалтын нийт үнэлгээний 50%

Явцын үнэлгээ нь долоо хоног бүрийн сургалтын агуулгад нийцсэн даалгавар, кейс судалгаа, семинарын оролцоо, дадлагын гүйцэтгэлээр дамжуулан суралцагчдын ахиц дэвшлийг тогтмол үнэлнэ.

Явцын үнэлгээний бүрэлдэхүүн:

- 1.1. Долоо хоногийн даалгавар, кейс судалгаа (20%)
- 1.2. Семинарын идэвх, багийн ажил (10%)
- 1.3. Дадлагын гүйцэтгэл (15%)
- 1.4. Явцын богино шалгалтууд – 4 удаа (5%)

2. Төгсгөлийн үнэлгээ (Summative assessment)

Сургалтын нийт үнэлгээний 50%

Сургалтын төгсгөлд суралцагчийн эзэмшсэн мэдлэг, ур чадвар, хандлагын цогц байдлыг нэгдсэн байдлаар үнэлж, чадамжийн түвшнийг баталгаажуулна.

- 2.1. Эцсийн онолын шалгалт – 20%

40–50 даалгавар

Сонгох, нөхөх, богино хариулт

Цөм агуулга 1–11 бүх модулийг хамарсан

Шалгуур босго: **≥70%**

- 2.2. Практик шалгалт (OSPE хэлбэр) – 15%

3–4 өртөөгөөр гүйцэтгэнэ:

- Тандалтын мэдээлэлд дүн шинжилгээ хийх
- Эрсдэлийн үнэлгээний матриц бөглөх
- Хүйтэн хэлхээний доголдлыг илрүүлэх
- Оношилгооны түргэвчилсэн тест ашиглах

Өртөө бүрд чадамжийн шалгуурт тулгуурласан үнэлгээ хийнэ.

2.3. Портфолио үнэлгээ – 10%

Суралцагч сургалтын туршид дараах ажлыг багцлан бүрдүүлнэ:

- Бие даалтын ажлууд
- Шийдвэрлэж, тайлагнасан тохиолдлууд
- Оролцогч талуудын шинжилгээ
- Богино бодлогын хураангуй
- Хүнсний, орчны, ХАБЭА үнэлгээний чеклист
- НЭМ үйл ажиллагааны жижиг төлөвлөгөө

Портфолио үнэлгээний шалгуур:

- Бүрэн байдал
- Чанар ба үнэн зөв байдал
- Нотолгоонд суурилсан дүгнэлт
- Шинжилгээний гүнзгийн байдал
- Ажлын байран дээр хэрэгжүүлэх боломж

2.4. Воркшопын интеграцчилсан төслийн ажил – 5%

12 дахь долоо хоногт зохион байгуулна.

Баг бүр дараах ажлуудын аль нэгийг гүйцэтгэнэ:

- Эрсдэлийн үнэлгээ + хариу арга хэмжээний төлөвлөгөө
- Хамтын ажиллагааны төлөвлөгөө (Joint Action Plan)
- НЭМ-ийн бодит асуудлаар нэг хуудас тайлан
- Өгөгдөлд суурилсан шийдвэрийн дүн шинжилгээ

3. Үнэлгээний дүн гаргалт

Суралцагч дараах шалгуурыг хангасан үед төгссөнд тооцно:

1. Явцын үнэлгээ $\geq 70\%$
2. Төгсгөлийн үнэлгээ $\geq 70\%$
3. Үүнд, эцсийн онолын шалгалт $\geq 70\%$ босго давсан байх
4. Портфолио шаардлагын дагуу бүрэн багцлагдсан байх

4. Үнэлгээний зарчим

- Чадамжид суурилсан, үнэлгээний олон аргыг хослуулсан
- Ил тод, ойлгомжтой шалгууртай байх

- Бодит ажлын байрны нөхцөлтэй уялдсан
- Суралцахуйн ахиц дэвшлийг дэмжсэн, зааварчилгаатай
- Суралцагчийн хариуцлага, оролцоог дэмжсэн

ЕС. НОМ ЗҮЙ

Энэхүү хөтөлбөрийн сургалт, дадлага, үнэлгээг хэрэгжүүлэхэд дараах үндсэн бүлгийн материалуудыг ашиглана.

I. Монгол Улсын хууль, бодлого, стандарт

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн бодлого, тандалт–хяналт, орчны эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, хөдөлмөрийн эрүүл мэндийн чиглэлээр мөрдөгдөж буй үндэсний хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, журам, удирдамжууд.

II. Үндэсний журам, заавар, мэргэжлийн удирдамж

Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журам, стандарт, аргачлал, заавар, үйл ажиллагааны удирдамж.

III. Олон улсын баримт бичиг, стандарт, аргачлал

Эрүүл мэндийн үндсэн чиг үүрэг, тандалт, хариу арга хэмжээ, эрүүл мэндийг дэмжих, бодлого боловсруулах, салбар хоорондын зохицуулалтын чиглэлээрх олон улсын нбайгууллагаас гаргасан удирдамж, дүрэм, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн.

IV. Судалгааны ном, сэтгүүл, шинжлэх ухааны эх сурвалц

Нотолгоонд суурилсан бодлого, эрүүл мэндийн системийн үнэлгээ, зан үйлийн өөрчлөлт, эрүүл мэндийн эдийн засаг, эпидемиологи, орчны эрүүл мэнд, эрсдэлийн удирдлагын чиглэлээр ашиглах үндсэн ном, гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүллүүд.

V. Сургалтын хэрэглэгдэхүүн, дадлагажих материал

Сургалтын явцад ашиглах практик материал, кейс судалгаа, дасгалын багц, симуляцийн хөтөлбөр, багшийн гарын авлага, цахим сургалтын платформ.

VI. Мэдээллийн систем, өгөгдлийн сан

Сургалтын практикт ашиглах бодит өгөгдөл, мэдээллийн системүүд.

VII. Багшийн гарын авлага, үнэлгээний хэрэгсэл

Чадамжийн шалгуурын үнэлгээний хуудас

Ажлын байрны дадлагын үнэлгээний маягт

Check-list, rubric, OSCE/OSPE загвар

Суралцагчийн багц ажил (portfolio) боловсруулах загвар